



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/427

Зуунмод

“Төв түмний цэнгэл-2022” баяр наадмын  
зохион байгуулах зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Төв түмний цэнгэл-2022” баяр наадмын салбар хороодын зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Арга хэмжээнд шаардагдах 12,939,210 (арван хоёр сая есөн зуун гучин есөн мянга хоёр зуун арав) төгрөгийг хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т, зарцуулахыг Ерөнхий нягтлан бодогч (Б.Одончимэг)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Отгонбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2022 оны 07 дугаар  
сарын 27-ны өдрийн А/127 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт

“ТӨВ ТҮМНИЙ ЦЭНГЭЛ-2022” БАЯР НААДМЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТОВЧОО

2022.07.26

Зуунмод

Д/д	Зардлын нэр	Зардлын нийт дүн
1	Үндэсний сурын харваа	1,987,400.00
2	Үндэсний бөх	1,760,490.00
3	Зохион байгуулах хороо	6,744,000.00
4	Шагайн харваа	933,600.00
5	Хэв журам	1,513,720.00
	Нийт дүн	12,939,210.00

ХЯНАСАН:  
САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН *шр* Ч.ЦЭЦЭГСҮРЭН  
ТООЦОО ГАРГАСАН:  
БАЯР НААДАМ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ  
НАРИЙН БИЧИГ *Б. Мөнхбат* Б.МӨНХБАТ